



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/598

Булган сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайд, Булган аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль" зохион байгуулахтай холбогдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагаас эхлэн гамшгаас хамгаалах "Өндөржүүлсэн бэлэн байдал"-ын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, алба болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлсүгэй.

3. Ажлын тусгай горимд шилжсэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/247 дугаар тушаалын хавсралт "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам"-ын хэрэгжилтийг хангуулан ажиллуулахыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн дарга, захирал (эрхлэгч) нарт үүрэг болгосугай.

4. "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль"-д шаардлагатай зардлыг гамшгаас хамгаалах сургууль зохион байгуулах зардлаас тооцон гаргаж, цаашид шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж



6325010821